



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар A/08

Амардалай

Ахмад настны харьяаллыг шинэчлэн
тогоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.9, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.6, 14.8, 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Тус сумын нийт ахмад настнуудын харьяаллыг хавсралтад дурдсанаар баталсугай.

Хоёр: Тухайн байгуулагад ажиллаж байсан болон энэхүү захирамжаар харьяалуулсан ахмадуудад хуулийн дагуу хүндэтгэл, дэмжлэг үзүүлэх, холбогдох мэдээллийг сумын Ахмадын хороонд заасан хугацаанд гарган өгч байхыг Баг, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарт үүрэг болгосугай.

Гурав: Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд биелэлтийг тооцон дүгнэж мэдээлэхийг сумын Ахмадын хорооны дарга Ж.Наранцэцэг/-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 01 дүгээр сарын 09 ны өдрийн A/03 тоот захирамжийг энэ өдрөөс хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ИШ-ЁНДОН



4880100010